



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

2019 оныг "Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил"<sup>т</sup>  
болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 198 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 19/16 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 380 жилийн ойн хүрээнд нийслэлийн төрийн үйлчилгээний чанар, төрийн байгууллагын чадавх, төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, нийслэл Улаанбаатар хотын бүтээн байгуулалт, дэд бүтэц, байгаль орчин, тохижилт, ногоон байгууламж, нийгмийн салбарын хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2019 оныг "Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил" болгон зарласугай.

2. "Иргэдийн оролцоотой – Хөгжлийн жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

3. "Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэн, төр, хувийн хэвшлийн байгууллагын саналыг тусган боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хэлэлцүүлэн батлуулахыг Ажлын хэсэг /П.Баярхүү/-т даалгасугай.

4. Салбарын хэмжээнд нийслэлийн иргэдийн талархлыг хүлээсэн ажлуудаа бататгаж, хүрсэн түвшнээ ахиулан, зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, нийслэлийн өдрийн өмнө үр дүнг тооцон ажиллахыг Нийслэлийн Засаг даргын орлогч, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нарт даалгасугай.

5. "Иргэдийн оролцоотой – Хөгжлийн жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж, ажлын явц, үр дүнг улирал тутамд Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсэг /П.Баярхүү/-т, зохион байгуулан хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг олон нийтэд тогтмол мэдээлж, сурталчлан ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Э.Дагиймаа/-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН  
БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ОРЛОГЧ

Ж.БАТБАЯСГАЛАН

### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга -Нийслэлийн Засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч
- Гишүүд:
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодын дарга нар /зөвшилцсөнөөр/;
  - Нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч – Нийслэлийн Засаг даргын орлогч;
  - Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч;
  - Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн дарга;
  - Багануур дүүргийн Засаг дарга;
  - Багахангай дүүргийн Засаг дарга;
  - Баянгол дүүргийн Засаг дарга;
  - Баянзүрх дүүргийн Засаг дарга;

- Налайх дүүргийн Засаг дарга;
- Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга;
- Сүхбаатар дүүргийн Засаг дарга;
- Хан-Уул дүүргийн Засаг дарга;
- Чингэлтэй дүүргийн Засаг дарга;
- Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын дарга;
- Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга;
- Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын дарга;
- Нийслэлийн Газрын албаны дарга;
- Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газрын дарга;
- Нийслэлийн Боловсролын газрын дарга;
- Нийслэлийн Байгаль орчны газрын дарга;
- Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын дарга;
- Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын дарга;
- Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга;
- Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын дарга;
- Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга;
- Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын дарга;
- Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга;
- Нийслэлийн Тээврийн газрын дарга;
- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга;
- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын дарга;
- Нийслэлийн Орон сууцны корпораци" ОНӨҮГ-ын захирал;
- Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК-ийн захирал.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга.

Нарийн бичгийн  
дарга